



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2025 оны 12 дугаар сар)

ГАРЧИГ

НЭГ. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.....	3
1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажлууд	3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол.....	3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол.....	4
1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр үзүүлсэн үйлчилгээ	5
1.1.4. Сэтгэл зүйн чиглэлээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээ.....	5
1.1.5. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн 2025 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн ажлын тайлан (хүснэгтээр).....	6
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо	6
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт	6
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт.....	7
ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.....	8
2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд.....	8
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд	8
2.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд	8
2.4. Нийгмийн даатгалын тасгийн 2025 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн ажлын тайлан (тоон дүнгээр)	9
ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ	10
3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ	10
3.2. Дотоод ажил	10

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

Тус төв нь төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 12 дугаар сард дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, иргэддээ төрийн үйлчилгээг хүргэж ажиллав.

НЭГ. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

(Тайлант хугацаа: 2025.11.20 - 2025.12.05¹)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажлууд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **369** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 15,078,720 вон, нутаг буцах зардал: 2,000,000 вон, ажил олгогчоос олгох 13 дахь сарын цалин: 12,167,775 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 3,000,000 вон зэрэг хэлбэрээр нийт **33,621,495** воныг Монгол Улсын **25** иргэнд олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн С.Х (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 4,820,020 вон, нутаг буцах зардал 500,000 воныг олгуулав.

- Иргэн З.Н-ийн (Е-9) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү нийт 2,972,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

¹ Тайлан гаргах хугацааг дараа оны эхнээс бусад нэгж (Нийгмийн даатгалын тасаг)-ийн үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор энэ удаад 2025.11.20 - 2025.12.05-аар сонгож тайлан гаргасан болно.

- Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад гэнэтийн ослын улмаас нас барсан иргэн Б.Б-гийн (Е-9) ар гэртэй холбогдож, нутаг буцах зардлын 500,000 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Б.М-д (Е-9) Самсунг даатгалд байршсан нутаг буцах зардал 500,000 вон, 13 дахь сарын цалин 3,368,000 воныг олгуулав.
- Д.Т-гийн (Е-9) 13 дахь сарын цалин болон нутаг буцах зардлын баримтыг бүрдүүлж Самсунг даатгал руу илгээсэн.
- Иргэн Б.С (Е-9) нь нутаг буцах болсон тул 13 дахь сарын цалин, нутаг буцах зардлыг олгуулахаар баримт бичгийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.Д-гийн 13 дахь сарын цалинг ажил олгогчоос нэхэмжлэн 2025.12.11-нд олгуулахаар тохиролцож гомдол гаргагчид мэдэгдсэн.
- Иргэн М.Б-гийн (Е-9) нутаг буцах хугацаа гүйцсэний даатгал 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал олгуулах хүсэлтийг Самсунг даатгал руу илгээсэн.
- Иргэн Б.А-гийн (Е-9) 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал олгуулах хүсэлтийг Самсунг даатгалд илгээв.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн Ж.Ц-гийн (F-6) 13 дахь сарын цалин нэхэмжилсэн өргөдлийг ажил олгогчтой тохиролцон шийдвэрлэж 5,422,109 вон олгуулав.
- Иргэн Т.Б-гийн (визгүй) ажилласан хугацаанд ногдох 13 дахь сарын цалин 3,773,675 воныг нэхэмжлэн олгуулав.
- Иргэн Д.Ш-ийн (визгүй) 2024.08.20-2025.10.22-ны өдрийг хүртэлх ажилласан хугацааны олгогдоогүй цалин 500,000 воныг олгуулсан.
- Иргэн Д.Г-гийн (визгүй) цалингаа авч чадаагүй гэх гомдлын дагуу Инчон хотын Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гаргаж, олгогдоогүй цалин хөлс болох 1,000,000 воныг олгуулав.
- Иргэн П.О-гийн (визгүй) 2025 оны 6, 7, 8 дугаар сард 26 хоног барилга дээр ажиллаад авч чадаагүй цалинг нэхэмжилж, ажил олгогчтой зөвшилцөж эхний барагдуулалт 2,000,000 воныг олгуулж, үлдэгдэл цалинг 12 дугаар сард багтаан олгуулахаар холбогдох шалгалт хийгдэж байна.
- Иргэн Ш.Б-гийн (визгүй) Е-9 визээр ажиллаж байсан хугацаанд төлсөн нутаг буцах зардлын даатгалын буцаан олголтыг нэхэмжилж Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газар (산업인력공단 경기북부지사) руу холбогдох баримтыг бүрдүүлэн илгээснээр 500,000 воныг олгуулсан. Тухайн иргэний сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд мэдүүлж өгсөн.
- Иргэн Э.Н-ийн (визгүй) олгогдоогүй цалин 1,500,000 воныг олгуулсан.
- Иргэн Ц.Г-гийн (визгүй) 13 дахь сарын цалингийн асуудлаар Хөдөлмөрийн хэлтэс (서울동부고용노동청)-т гаргасан өргөдлийн явцыг тодруулж, тайлант хугацаанд ажил олгогчтой 2 удаа, Хөдөлмөрийн хэлтсийн байцаагчтай 3 удаа холбогдсон. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам (ХЭХЯ)-наас өргөдөл гаргагчийн талд хянан шийдвэрлэсэн ба ажил олгогч барагдуулалт хийх асуудал хүлээгдэж байна.
- Иргэн Л.Д-гийн (визгүй) сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргуулах хүсэлтийг мэдүүлсэн.

- Иргэн А.У-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлсийг олгуулах хүсэлтийг 2025.12.03-ны өдөр хүлээн авч материал бүрдүүлэн ажиллаж байна.

- Иргэн Г.Д-гийн (визгүй) 13 дахь сарын цалинг олгуулах хүсэлтийг 2025.12.03-ны өдөр хүлээн авч материал бүрдүүлэн ажиллаж байна.

- Иргэн Ц.Т-гийн (визгүй) PCNC цэвэрлэгээний компанид ажилласан 13 дахь сарын цалингийн асуудлаар гаргасан өргөдлийг хянаж үзэхэд өргөдлийн бүрдүүлбэр хангагдаагүй тул өргөдөл гаргагчид мэдэгдэн шийдвэрлэв.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр үзүүлсэн үйлчилгээ

БНСУ-ын 행동하는의사회 (Doctor's action for health) байгууллагатай хамтран 2025 оны 11 сарын 29-ний өдөр эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээг зохион байгуулж, визгүй 11 иргэнд орчуулгын тусалцаа үзүүлэн, 1,375,000 воны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэв.

1.1.4. Сэтгэл зүйн чиглэлээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн иргэдийн сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор судалгаа зохион байгуулж үр дүнгийн талаар дүгнэлт гаргаж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант хугацаанд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, сэтгэл заслын аргууд болох танин мэдэхүйн, төрх үйлийн болон картын аргыг ашиглан 3 иргэнд сэтгэл зүйн тусламж үзүүлэв. Үүнд:

- Айдас, сэтгэл түгшилтийн асуудлаар: 5
- Бусад шалтгаанаар: 2

1.1.5. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 6 иргэнийг, E-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 3 иргэнийг шинээр бүртгэсэн.

- E-7-4 визний асуудлаар нийт 32 иргэнтэй утас болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

- Хөдөлмөрийн гэрээний E-9 визээс E-7-4 визний ангилал руу шилжихээр өргөдөл гаргасан Ц.Буяндэлгэр, Б.Энхцог нарын өргөдлийг хүлээн авч оноо тоолж, визний шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, анхаарах асуудлын талаар зөвлөн, ажил олгогчтой нь холбогдож орчуулга хийх, баримт бичгийг хянаж, цахимаар мэдүүлэх зэргээр визээ мэдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэв.

- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн

тоо 717 хүрээд байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд 11 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн 2025 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн ажлын тайлан (хүснэгтээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо

д/д	Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
			Иргэн	Олгуулсан дүн (вон)
1	Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	Нутаг буцах зардал	4	2,000,000
2		Цалин, илүү цагийн хөлс		
3		Самсунгийн 13 дахь сарын цалин	3	15,078,720
4		Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	1	2,972,000
5		Үйлдвэрлэлийн ослын даатгал		
6		Гэнэтийн ослын даатгал		
7		Гэнэт халагдсаны тэтгэмж		
8		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
9	Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	1	1,000,000
10		13 дахь сарын цалин	1	5,422,100
11		Үйлдвэрлэлийн ослын даатгал		
12		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
13	Хууль бусаар оршин суудаг иргэдэд	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	3	2,000,000
14		13 дахь сарын цалин	1	3,773,675
15		Үйлдвэрлэлийн ослын даатгал		
16		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	11	1,375,000
Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн			25	33,621,495

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
57	9	41	23	-	16

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

1	Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	15	
2	Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	15	
3	Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	34	
4	Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	47	
5	Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	12	
6	Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	1	
7	Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	4	
8	Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх	13	
9	Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	3	
10	Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар (Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга)	45	
11	Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	11	
12	Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		
13	Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх		
14	Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	6	
15	Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	33	
16	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	31	
17	Бусад мэдээлэл, зөвлөгөө	80	
18	ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх	19	
Үзүүлсэн үйлчилгээний тоо		Утсаар	285
		Цахимаар	47
		Танхимаар	36
		Нийт	369

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

(Тайлант хугацаа: 2025.12.01- 2025.12.31)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс: 23 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 40 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 2 иргэнд гэж үрэгдүүлсний улмаас дахин олгосон;
- 41 иргэнд шинээр гэрчилгээ олгосон;

Нийт 83 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс: 40 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 23 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан.
- иргэнд дахин гэрчилгээ олгосон.
- 16 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 39 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг 318,177,574 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 76 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 89,210,104.2 төгрөгийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2025 оны 12 дугаар сард нийт 134 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 106,828,809 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 43 даатгуулагчийн 40,549,520 төгрөг, сайн дурын даатгалын 91 даатгуулагчийн 66,279,289 төгрөг байна.

2.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас, цахим, танхимаар нийт 289 иргэн, даатгуулагчид үйлчилгээг үзүүлсэн.

2) Тайлант хугацаанд төвийн фэйсбүүк хуудсаар нийгмийн даатгалын ач холбогдол, мөнгөжүүлсэн орлого, сайн дурын даатгалд хэрхэн хамрагдах, өндөр насны тэтгэврийг хэрхэн тогтоолгох, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг хэрхэн авах зэрэг сэдвээр 5 удаагийн богино хэмжээний сурталчилгааны бичлэг, 1 удаагийн подкастыг нийтэд түгээсэн.

2.4. Нийгмийн даатгалын тасгийн 2025 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн ажлын тайлан (тоон дүнгээр)

№	Үйлчилгээ	Тоо	Өссөн дүнгээр	
1	Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	23	312
		Сайн дурын даатгал	40	344
2	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон /Албан журам/	Шинээр	41	251
		Дахин	2	80
		Хугацаа сунгасан	40	338
3	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон /Сайн дур/	Шинээр	16	296
		Дахин	0	74
		Хугацаа сунгасан	23	223
4	Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал /воноор/	42,946,000.00	462,836,000.00
		Сайн дурын даатгал	214,248,254.00	1,791,691,945.94
		Нийт	318,177,574.00 76%	2,936,090,765.49 58.35%
5	3 болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	40,549,520.00	302,313,595.00
		Сайн дур	66,279,289.00	270,684,122.00
6	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт/вон/	Нэхэмжилсэн		211,344,890
		Олгосон	0	123,505,850
		Буцаан олголт авсан хүний тоо	0	25
7	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	198	3641
		Цахимаар	61	160
		Танхимаар	30	497

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ

Төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” социал хуудсанд 22, youtube сувагт 9, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 22 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж түгээсэн. Иргэдээс эдгээр зөвлөгөө, мэдээлэлд 207,986 удаа (давхардсан тоогоор) ханджээ.

Төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн <https://control.e-mongolia.mn/auth/login> веб сайтад 215 мэдээлэл байршуулсан.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийнхээ ажлын байранд очиж нөхцөл байдалтай нь танилцах, тулгамдсан асуудал, санал хүсэлтийг нь сонсох, шийдвэрлэх ажлын хүрээнд дараах үйлдвэрүүдэд ажиллав. Үүнд:

- 2025.11.29-ний өдөр Консулын хэлтэстэй хамтран БНСУ-ын Жэжү хотод байрлах (주)도시종합철강 болон Namhyun Kimchi үйлдвэрүүдээр зочлон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдтэй уулзалт зохион байгуулсан.
- 2025.12.03-ны өдөр Монгол Улсын Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн хамт Гёнги аймгийн Пучон хотод байрлах LAON CORPORATION тавилгын үйлдвэрийн удирдлага Пак Юн Жү болон тус үйлдвэрт хөдөлмөр эрхэлж буй 10 хөдөлмөрийн гэрээт ажилчинтай уулзалт зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү, Ичон хот дахь Олон улсын сургалтын төвд E-9 визний ангиллаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирж буй 34 хөдөлмөрийн гэрээт ажилтанд ирсний дараах сургалтыг танхимаар (2025.12.18) зохион байгуулсан.

3.2. Дотоод ажил

Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг тус тус шинэчилж, нутаг буцсан иргэдийн мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газар (ХХҮЕГ)-т хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн албан даалгавар (3 үүрэг)-ын хэрэгжилтийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газар (ХХҮЕГ)-т (2025.11.24-ний өдрийн 1/185 тоот) албан бичгээр хүргүүлэв.

Төвийн нийт албан хаагчдийг дараах сургалтад хамруулав. Үүнд:

- “Чадахуйн зарчмын хэрэгжилт, байгууллагын үнэлгээнд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан (2025.12.04) Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим мэдээлэлд нийт албан хаагчид оролцов.
- “DATA ANALYSIS” практик сургалт (2025.12.8-11-ний өдөр)-д албан хаагчдаа хамруулж, EXCEL&POWER BI, AI хэрэгслийг ашиглан өгөгдлийг үр дүнтэй боловсруулах, дата шинжилгээ хийх ур чадварт сургасан.
- Төвийн 5 албан хаагч Умард Чүнчон аймгийн Жэчон хотод байрлах БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа ХАБЭАХЭГ-ын сургалтын

чадамжийн төвд “Барилгын болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажлын талбар дахь осол гэмтлийн төрлүүд, ослоос сэргийлэх, хамгаалах арга” сэдвээр аюулгүй ажиллагааны сургалт (2025.12.10)-д хамрагдав.

--- оОо ---